

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/105/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn

Аудитор: Л.Отгон

Утас: 99059489 Цахим хаяг: devjikhcapital.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2025/105/НА-СТА-ТШЗ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02.24 № 82

танай _____ -ны № _____ -т

ЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С. АМГАЛАН
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодсх бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.4, 16 дугаар зүйлийн 16.5.5, 24 дүгээр зүйлийн 24.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Шилэн дансны тухай хуулийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Ажиллагсад үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 440.1 мянган төгрөгийг илүү слгосон;
- Засаг даргын нөөц хөрөнгөөс шагнал урамшуулалд 4,270.0 мянган төгрөгийг зарцуулсан;
- Тайлант онд дансанд бүртгэлтэй 119,117.8 мянган төгрөгийн бараа материалыг тоолоогүй, тооцоо бодож баталгаажуулаагүй байна.

8225020204

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд сумын 100 жилийн ой тохиож аймгийн төсвөөс 100,000.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосноос Соёлын төвийн гадна засварыг хийлгэж, ширээ сандал, танилцуулгын самбарт 55,000.0 мянган төгрөг зарцуулан, 45,000.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Иргэд болон байгууллагаас 111,005.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хандиваар орлого авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд орон нутгийн төсвөөс 754,871.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс 59,835.6 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлжээ.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Орон нутгийн хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээс 264,505.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 8 зорилт 203 арга хэмжээ хэрэгжүүлэхээр сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувь байна;

Аймгийн Засаг даргын захирамжийн хүрээнд "Нээлттэй Алтай" хөтөлбөрийн үр дүнгээр шинээр гэр бүл болсон 4 залуу малчин өрхөд тус бүр 50 толгой эм ямаагаар малжуулах ажлыг зохион байгуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй багалгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	392,093,886.50	346,404,820.00
33	АВЛАГА	56,325,866.50	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	91,827.50	-
33500	Бусад авлага	56,234,039.00	-
33510	Байгууллагаас авах авлага	56,234,039.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	335,768,020.00	346,404,820.00
35400	Хангамжийн материал	112,479,020.00	123,115,820.00
35410	Бичиг хэргийн материал	920,000.00	576,000.00
35420	Аж ахуйн материал	109,619,020.00	119,117,820.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,190,000.00	1,190,000.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	1,482,000.00
35470	Бусад хангамжийн материал	750,000.00	750,000.00
35600	Мал амьтад	223,289,000.00	223,289,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,880,613,990.87	2,030,245,349.03
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,880,613,990.87	2,030,245,349.03
39200	Биет хөрөнгө	1,139,019,990.87	1,288,381,349.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	877,322,890.43	1,016,422,890.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	(234,189,869.94)	(287,100,465.50)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	73,000,000.00	125,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(44,374,999.88)	(53,624,999.84)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	45,748,520.00	37,068,520.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,071,594.04)	(19,138,161.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,745,000.00	47,180,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,492,186.15)	(16,309,037.99)
39209	Зам, гүүрийн байгууламж	108,667,146.00	108,667,146.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(19,733,436.78)	(25,416,794.10)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	130,892,000.00	130,892,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	254,161,100.00	291,961,100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(42,654,578.77)	(67,220,848.77)
39300	Биет бус хөрөнгө	741,594,000.00	741,864,000.00
39301	Програм хангамж	360,000.00	360,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(270,000.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	741,504,000.00	741,504,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,272,707,877.37	2,376,650,169.03
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	834,725.00	27,424,264.70
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	834,725.00	27,424,264.70
41300	Өглөг	834,725.00	27,424,264.70
41310	Ажилчидтай хог богдсон өглөг	834,725.00	-
41360	Бусад өглөг	-	27,424,264.70
41361	Байгууллагад төлөх өглөг	-	6,110,884.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	-	5,487,238.00
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	-	15,826,142.70
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,271,873,152.37	2,349,225,904.33
51	Засгийн газрын хувь оролцоо	2,271,873,152.37	2,349,225,904.33
51100	Засгийн газрын оруулсан капитал	389,151,152.00	389,151,152.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	389,151,152.00	389,151,152.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,513,933,645.23	1,591,286,397.19

Жаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	1,312,381,343.06	1,513,933,645.23
51220	Тайлант үеийн үр дүн	201,552,302.17	77,352,751.96
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	368,788,355.14	368,788,355.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,272,707,877.37	2,376,650,169.03

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	985,148,934.00	1,265,211,034.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	226,862,168.00	280,385,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	226,862,168.00	280,385,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	14,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0	14,000,000.00
120009	Бусад орлого	0	1,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	205,898,168.00	265,385,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	20,964,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	758,286,766.00	984,826,034.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	155,739,766.00	159,253,034.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,847,200.00	20,265,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	125,632,566.00	138,623,034.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	260,000.00	365,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	602,547,000.00	825,573,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	602,547,000.00	825,573,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	783,596,631.83	1,186,800,282.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	783,596,631.83	1,186,800,282.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	729,689,471.09	1,047,382,499.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	314,474,699.26	519,080,556.02
210101	Үндсэн цалин	182,827,667.00	261,068,947.93
210102	Нэмэгдэл	68,304,474.00	177,874,993.09
210104	Урамшуулал	41,160,955.26	40,061,358.00
210105	Гэрээт ажлын хөлс	22,181,603.00	40,075,257.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,194,744.50	64,747,173.23
210201	Тэтгэврийн даатгал	29,315,929.50	43,871,064.21
210202	Тэтгэмжийн даатгал	2,503,200.00	5,061,664.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,947,841.00	3,102,255.96
210204	Ажилгүйдлийн даатгал	493,516.00	2,472,834.67
210205	Эрүүл мэндийн даатгал	4,934,258.00	10,239,354.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,505,686.00	56,902,559.32
210301	Гэрэл, цахилгаан	2,885,389.00	4,470,847.32
210302	Түлш, халаалт	38,620,297.00	50,531,712.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	1,900,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,510,753.25	74,999,167.00
210401	Бичиг хэрэг	8,043,213.00	5,975,100.00
210402	Тээвэр, шатахуун	35,022,077.00	38,418,764.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	916,730.00	1,214,803.00

Жаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,528,733.25	29,390,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	62,220,650.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	12,439,000.00	15,516,500.00
210702	Дотоод албан томилолт	12,439,000.00	15,516,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,550,227.00	144,639,561.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,125,777.00	143,104,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	264,450.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	800,000.00	1,095,061.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	154,793,711.08	171,496,982.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,628,500.00	42,801,340.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	140,165,211.08	128,695,642.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,907,160.74	139,417,783.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,938,100.00	22,923,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	17,502,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,868,100.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,070,000.00	5,421,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,969,060.74	116,494,283.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,969,060.74	116,494,283.63
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	201,552,302.17	78,410,751.16
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,057,999.20
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	1,057,999.20
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	201,552,302.17	77,352,751.96

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	760,286,766.00	1,041,060,073.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,000,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	2,000,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,000,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	758,286,766.00	1,041,060,073.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	155,739,766.00	215,487,073.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,847,200.00	20,265,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	125,632,566.00	194,857,073.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	260,000.00	365,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	602,547,000.00	825,573,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	602,547,000.00	825,573,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	703,042,766.00	1,041,060,073.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	703,042,766.00	1,041,060,073.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	592,901,566.26	901,642,289.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	313,639,974.26	504,904,937.75
210101	Үндсэн цалин	181,992,942.00	206,751,568.00
210102	Нэмэгдэл	68,304,474.00	221,437,060.75
210104	Урамшуулал	41,160,955.26	40,272,002.00
210105	Гэрээт ажлын хөлс	22,181,603.00	36,444,307.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,286,572.00	58,286,308.30
210201	Тэтгэврийн даатгал	29,407,757.00	39,659,399.87
210202	Тэтгэмжийн даатгал	2,503,200.00	4,666,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,947,841.00	2,333,099.31
210204	Ажилгүйдлийн даатгал	493,516.00	2,296,309.12
210205	Эрүүл мэндийн даатгал	4,934,258.00	9,331,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,505,686.00	50,961,175.32

Жаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	2,885,389.00	4,471,047.32
210302	Түлш, халаалт	38,620,297.00	44,590,128.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	1,900,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,885,107.00	62,404,567.00
210401	Бичиг хэрэг	7,125,250.00	5,141,600.00
210402	Тээвэр, шатахуун	34,246,577.00	39,310,764.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	916,730.00	1,214,803.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,596,550.00	16,737,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,305,000.00	8,568,100.00
210604	Урсгал засвар	26,305,000.00	8,568,100.00
2107	Томилолт, зочны зардал	12,439,000.00	15,516,500.00
210702	Дотоод албан томилолт	12,439,000.00	15,516,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	92,150,227.00	143,705,561.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,725,777.00	142,170,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	264,450.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	800,000.00	1,095,061.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,690,000.00	57,295,140.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,690,000.00	57,295,140.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	110,141,199.74	139,417,783.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,938,100.00	22,923,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	17,502,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,868,100.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,070,000.00	5,421,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	70,203,099.74	116,494,283.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,969,060.74	116,494,283.63
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	56,234,039.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	57,244,000.00	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	57,244,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	57,244,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	57,244,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	57,244,000.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(57,244,000.00)	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	389,151,152.00	368,788,355.14	1,312,381,343.06	2,070,320,850.20
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	389,151,152.00	368,788,355.14	1,312,381,343.06	2,070,320,850.20
9	Тайлант үеийн үр дүн	-	-	201,552,302.17	201,552,302.17
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	389,151,152.00	368,788,355.14	1,513,933,645.23	2,271,873,152.37
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	389,151,152.00	368,788,355.14	1,513,933,645.23	2,271,873,152.37
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	389,151,152.00	368,788,355.14	1,513,933,645.23	2,271,873,152.37
19	Тайлант үеийн үр дүн	-	-	77,352,751.96	77,352,751.96
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	389,151,152.00	368,788,355.14	1,591,286,397.19	2,349,225,904.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү	Биелэлт хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	825,573,000.00	777,265,285.37	48,307,714.63	94.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	825,573,000.00	777,265,285.37	48,307,714.63	94.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	802,071,000.00	754,341,785.37	47,729,214.63	94.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	509,000,000.00	504,904,937.75	4,095,062.25	99.20
210101	Үндсэн цалин	149,000,000.00	206,751,568.00	(57,751,568.00)	138.76
210102	Нэмэгдэл	246,300,000.00	221,437,060.75	24,862,939.25	89.91
210104	Урамшуулал	80,100,000.00	40,272,002.00	39,827,998.00	50.28
210105	Гэрээт ажлын хөлс	33,600,000.00	36,444,307.00	(2,844,307.00)	108.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,625,000.00	58,286,308.30	5,338,691.70	91.61
210201	Тэтгэврийн даатгал	43,265,000.00	39,659,399.87	3,605,600.13	91.67
210202	Тэтгэмжийн даатгал	5,090,000.00	4,666,200.00	423,800.00	91.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,072,000.00	2,333,099.31	1,738,900.69	57.30
210204	Ажилгүйдлийн даатгал	1,018,000.00	2,296,309.12	(1,278,309.12)	225.57
210205	Эрүүл мэндийн даатгал	10,180,000.00	9,331,300.00	848,700.00	91.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,500,000.00	50,961,175.32	5,538,824.68	90.20
210301	Гэрэл, цахилгаан	4,500,000.00	4,471,047.32	28,952.68	99.36
210302	Түлш, халаалт	50,000,000.00	44,590,128.00	5,409,872.00	89.18
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	1,900,000.00	100,000.00	95.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,341,000.00	51,091,783.00	1,249,217.00	97.61
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	5,141,600.00	(141,600.00)	102.83
210402	Тээвэр, шатахуун	28,000,000.00	27,997,980.00	2,020.00	99.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	1,214,803.00	785,197.00	60.74
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,341,000.00	16,737,400.00	603,600.00	96.52
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,000,000.00	8,568,100.00	2,431,900.00	77.89
210604	Урсгал засвар	11,000,000.00	8,568,100.00	2,431,900.00	77.89

Жаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	18,000,000.00	15,516,500.00	2,483,500.00	86.20
210702	Дотоод албан томилолт	18,000,000.00	15,516,500.00	2,483,500.00	86.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,605,000.00	8,100,561.00	16,504,439.00	32.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,600,000.00	6,565,500.00	15,034,500.00	30.40
210803	Даатгалын үйлчилгээ	800,000.00	-	800,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	165,000.00	-	165,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000.00	-	90,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	440,000.00	10,000.00	97.78
210807	Газрын төлбөр	1,500,000.00	1,095,061.00	404,939.00	73.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,000,000.00	56,912,420.00	10,087,580.00	84.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,000,000.00	56,912,420.00	10,087,580.00	84.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,502,000.00	22,923,500.00	578,500.00	97.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,502,000.00	22,923,500.00	578,500.00	97.54
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,502,000.00	17,502,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,000,000.00	5,421,500.00	578,500.00	90.36
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	825,573,000.00	777,265,285.37	48,307,714.63	94.15
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	825,573,000.00	777,265,285.37	48,307,714.63	94.15
320001	Орон нутгийн төсвөөс	825,573,000.00	777,265,285.37	48,307,714.63	94.15
62.00	АЖИЛЛАГСДЫН ТОО	21	21	-	100.00
620001	Удирдах ажилтан	7	7	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-	100.00

2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	155,829,766.00	215,487,073.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	155,829,766.00	215,487,073.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	99,505,727.00	147,300,504.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,263,727.00	11,312,784.00
210402	Тээвэр, шатахуун	15,263,727.00	11,312,784.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	84,242,000.00	135,605,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	84,242,000.00	135,605,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	382,720.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	382,720.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,324,039.00	68,186,569.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	56,324,039.00	68,186,569.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	56,324,039.00	68,186,569.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	155,739,766.00	215,487,073.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	155,739,766.00	215,487,073.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,847,200.00	20,265,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	125,632,566.00	194,857,073.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	260,000.00	365,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жаргалан сумын Засаг даргын Тамгын газар нь иргэд олон нийтийн санал санаачилгад тулгуурлан төрийн үйлчилгээг иргэн бүрд шуурхай жигд хүртээмжтэй үнэнч шударгаар хүргэх зорилготой байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг” шинэчлэн тогтоосон,
- Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны, төрийн үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох журам”,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Жаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 103,942.3 мянган төгрөгөөр буюу 4.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	56,325.9	0.0	(56,325.9)
Бараа материал	335,768.0	346,404.8	10,636.8
Үндсэн хөрөнгө	1,880,613.9	2,030,245.3	149,631.4
Нийт хөрөнгө	2,272,707.9	2,376,650.2	103,942.3
Өр төлбөр	834.7	27,424.3	26,589.6
Засгийн газрын хувь оролцоо	2,271,873.2	2,349,225.9	77,352.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,272,707.9	2,376,650.2	103,942.3

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага үндсэн хөрөнгө, бараа материал, өглөгийн данс байна. Тухайлбал:

Авлага данс үлдэгдэлгүй болсон.

Бараа материал дансны үлдэгдэл 346,404.0 мянган төгрөг болж, 10,636.8 мянган төгрөгөөр өссөн.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 88,624.4 мянган төгрөгийн бичиг хэрэг, шатахуун, аж ахуйн материал худалдан авсан, 77,987.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,030.2 мянган төгрөг болж, 149.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд орон нутгийн хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээс 139,100.0 мянган төгрөгийн барилга, 60,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 25,405.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 40,000.0 мянган төгрөгийн бусад хөрөнгө үнэ төлбөргүйгээр бүртгэсэн байна.

Өглөг дансны үлдэгдэл 26,589.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь аймгаас авах татаас санхүүжилтийн орлогоос шалтгаалж, ХХОАТ-ын өр, нийгмийн даатгалын шимтгэлийн өр, бусад байгууллагад өртэй гарсан байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 1,591,286.4 мянган төгрөг болж, 77,352.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны санхүүгийн үр дүнгээс шалтгаалжээ.

Жаргалан сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 279,062.1 мянган төгрөгөөр буюу 22.1 хувиар, нийт зардал өмнөх оноос 402,505.1 мянган төгрөгөөр буюу 33,9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь төсвийн захирагчдаас хуваарилсан санхүүжилт 223,026.0 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 73,513.3 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Орон нутгийн төсвөөс олгох, шилжүүлгийн данс өмнөх оноос 223,026.0 мянган төгрөгөөр өссөн нь цалин хөлс, орон нутагт ажилласны нэмэгдлийг олгодог болсонтой холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 812,573.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс нийт 13,000.0 мянган төгрөгөөр зардлыг өсгөж, 825,573.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэх 825,573.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр урсгал үйл ажиллагааны зардалд 777,265.3 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсвөөс 48,307.7 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 777,265.3 мянган төгрөг буюу 94.15 хувь зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөг)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
	Код	Нэр				
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	754,871.0	707,585.4	47,285.6	93.73
2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	23,502.0	22,923.5	578.5	97.54
3	81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	47,200.0	46,756.4	443.6	99.06
Дүн			825,573.0	777,265.3	48,307.7	94.15

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 365.0 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-аас 194,857.1 мянган төгрөг /малжуулалт, онцгой байдлын шатахуун бусад хөтөлбөрийн хүрээнд/, ЗДНХ-өөс бусад ангилагдаагүй хөрөнгөнөөс 20,265.0 мянган төгрөгийн тусламж дэмжлэг авч, 147,300.5 мянган төгрөгийг зарцуулж, 68,186.6 мянган төгрөгийг төвлөрүүлэх шилжүүлгээр бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Жаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хооронд Дэвжих капитал аудит ХХК-ийн аудитор Л.Отгон гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор Д.Цэрэнханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 3/26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгээр сонгосон зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 825,573.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,383.6 мянган төгрөгөөр тогтоосныг дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шалгагдагч байгууллага нь холбогдох зардлуудыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5, 6.4.8 заасныг түүвэрлэн авч үзэхэд 938.6 мянган төгрөгийн 29 мэдээллийг ил тод байршуулахаас 543.0 мянган төгрөгийн 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 319.8 мянган төгрөгийн 8 мэдээллийг байршуулаагүй хуулийн хэрэгжилт 85.0 хувьтай байна

Шийдвэрлэлт: Шилэн дансны цахим системд мэдээлэл бүрэн оруулах зөвлөмж хүргүүлсэн

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 77,891.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 4 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

(мянган төгрөг)

Жаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	75,549.0	4	75,549.0	100.0
Төлбөрийн акт	1	2,342.6	1	2,342.6	100.0
Нийт дүн	5	77,891.6	10	77,891.6	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Худалдан авах ажиллагаа, засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг анхаарч үзэх нь зүйтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Аудитаар 166,885.5 мянган төгрөгийн алдаа¹ -г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- 100 жилийн ойн санхүүжилтээс авсан 20,000.0 мянган төгрөгийн самбар, 17,141.0 мянган төгрөгийн өртөгтэй нийтийн бие засах эко нойлыг үндсэн хөрөнгөөр тусгаагүй;
- Нэмэлт санхүүжилтийн орлого 56,234.0 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тайлагнаагүй;
- Нийгмийн даатгалын өглөг, халаалтын өглөгийг 5,941.2 мянган төгрөгөөр дутуу тусгасан;
- Төвлөрүүлэх шилжүүлэг 67,569.3 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал буруу тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн.

Залруулагдаагүй нийт 123,827.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 123,827.9 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрч 440.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 123,387.8 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

5.2 Төлбөрийн акт

1. Ажиллагсад үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 440.1 мянган төгрөгийг илүү олгосон.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Албан шаардлага

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс шагнал урамшуулалд 4,270.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Тайлант онд данс бүртгэлд бүртгэлтэй 119,117.8 мянган төгрөгийн бараа материалыг тоолоогүй, тооцоо бодоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалыг тоолоогүй, тооцоо бодоогүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 166,885.5 мянган төгрөгийн алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**
- 100 жилийн ойн санхүүжилтээс авсан 20,000.0 мянган төгрөгийн самбар, 17,141.0 мянган төгрөгийн өртөгтэй нийтийн бие засах эко нойлыг үндсэн хөрөнгөөр тусгаагүй;
- Нэмэлт санхүүжилтийн орлого 56,234.0 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тайлагнаагүй;
- Нийгмийн даатгалын өглөг, халаалтын өглөгийг 5,941.2 мянган төгрөгөөр дутуу тусгасан;
- Төвлөрүүлэх шилжүүлэг 67,569.3 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал буруу тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн.

Залруулагдаагүй нийт 123,827.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 123,827.9 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрч 440.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 123,387.8 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага, шилэн дансны цахимд мэдээлэл бүрэн гүйцэд оруулах 1 зөвлөмж хүргүүлсэн.

Төлбөрийн акт

1. Ажиллагсад үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 440.1 мянган төгрөгийг илүү олгосон.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс шагнал урамшуулалд 4,270.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Тайлант онд данс бүртгэлд бүртгэлтэй 119,117.8 мянган төгрөгийн бараа материалыг тоолоогүй, тооцоо бодоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ"., 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалыг тоолоогүй, тооцоо бодоогүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодогч бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим системд 938.6 мянган төгрөгийн 29 мэдээллийг ил тод байршуулахаас 543.0 мянган төгрөгийн 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 319.8 мянган төгрөгийн 8 мэдээллийг байршуулаагүй хуулийн хэрэгжилт 85.0 хувьтай байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;", 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;", 6.4.8-т "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэж заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим системд мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн оруулж байх зөвлөмж хүргүүлэв.

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/ мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
Жаргалан сумын Засаг даргын Тамгын газар	4	166,885.5					4	166,885.5				
Дүн	4	166,885.5					4	166,885.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/										
			Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
Жаргалан сумын Засаг даргын Тамгын газар	3	123,827.9	1	440.1	2	123,387.8							
Дүн	3	123,827.9	1	440.1	2	123,387.8	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/							
			Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн	24	862.8	-	-	-	-	-	-	24	862.8
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-
-Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		